



2026 ОНЫ 6-Р САРЫН 11

SFA-ийн нэр томъёоны тайлбар толь

ХУВИЛБАР 1.5



ТОГТВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

Зорилго

Энэхүү тайлбар толийн зорилго нь SFA стандартад хэрэглэдэг нэр томъёонуудын утгыг ойлгомжтой, тодорхой тайлбарлахад оршино. Энэхүү тайлбар толийг боловсруулахдаа ISEAL-ийн тогтвортой байдлын тогтолцооны зохистой дадлын дүрэм (<https://ISEAlliance.org/what-we-do/credible-practice/ISEAL-code-good-practice-sustainability-systems>)-д үндэслэн нийтлэг хэрэглэдэг нэр томъёонуудыг тодорхойлсон. ISEAL-ийн зарим нэр томъёог SFA-ийн хэрэглээний шаардлагад нийцүүлэн өөрчилсөн болно.

Энэхүү тайлбар тольд ороогүй нэр томъёоны хувьд ISEAL-ийн дүрэм ашиглахыг SFA-аас зөвлөж байна.

Энэхүү нэр томъёоны тайлбар толийг SFA-ийн үндсэн хэл дээр нийтэлнэ. Аливаа зөрүү эсвэл тодорхойгүй байдал гарсан тохиолдолд англи хувилбарыг баримтална.

SFA-ийн нэр томьёоны тайлбар толь

Нэр томьёо	Тодорхойлолт
“SFA Certified” бүтээгдэхүүн	SFA-ийн “Малын гаралтай ширхэгт” стандартын дагуу бэлтгэн нийлүүлсэн, SFA-ийн “Цэвэр ноолуур боловсруулах” стандартын дагуу боловсруулсан, SFA-ийн “Мөшгөлтийн тогтолцоо” стандартын дагуу худалдаалсан бүтээгдэхүүн.
Итгэмжлэл	Үнэлгээний тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэхдээ өөрийн чадавх, шударга байдал, түүштай ажиллагааг албан ёсоор нотлон харуулах баталгаа гаргагчдад холбогдолтой гуравдагч талын баталгаа. Тайлбар 1: ISO 17011 стандартад нийцсэн байдлаар хийгдсэн итгэмжлэлийг хэлнэ (ISEAL). Итгэмжлэл нь нийцлийн албан ёсны нотолгоо боловч байнга нийцэж буйд мониторинг хийхийн тулд хяналт шаардлагатай. Тайлбар 2: SFA нь схем эзэмшигч бөгөөд Итгэмжлэлийн байгууллага биш юм. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь бие даасан хөндлөнгийн итгэмжлэл (жишээлбэл, IAF-ийн MLA-д нэгдсэн байгууллагаас) авсан байх ба үүнд үндэслэн “SFA-ийн батламжилсан” статустай болно.
Зарга	Үнэлгээний шийдвэрийг дахин авч үзэх талаар тухайн аж ахуйн нэгжээс ТҮБ-д эсвэл ТҮБ-аас хяналтын байгууллагад гаргасан албан ёсны хүсэлт. Зарга болон шийдвэрийг заавал баримтжуулна.
Анхны үнэлгээ	Тухайн аж ахуйн нэгжид хамрах хүрээний гэрчилгээг анх удаа олгох боломжтой эсэхийг тодорхойлохын тулд тодорхой стандартын бүх шаардлагын дагуу тухайн аж ахуйн нэгжид хийх анхны бүрэн үнэлгээ.
Мониторингийн үнэлгээ	Аль нэг хувь хүн, аж ахуй нэгжийн эсрэг нотолгоо бүхий гомдолд эсвэл SFA-ийн стандартын тогтолцооны бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлөх олон нийтийн мэдээлэлд үндэслэн ТҮБ-аас тухайн аж ахуй нэгжийн төлөвлөгөөт хяналтын үнэлгээнээс гадна хийх үнэлгээ.
Давтан үнэлгээ	Анхны үнэлгээний дараа хийх аливаа бүрэн хэмжээний үнэлгээ. Хамрах хүрээний гэрчилгээг өмнө нь авсан аж ахуйн нэгжид шинээр хамрах хүрээний гэрчилгээг олгох боломжтой эсэхийг тодорхойлно.
Зайны үнэлгээ	Зөвхөн цахим хэрэгсэл (видео уулзалт, баримт бичгийг цахимаар хянах гэх мэт)-ийг ашиглан хийх үнэлгээ. Хэсэгчилсэн (өөрөөр хэлбэл газар дээр нь очихыг багасгах) эсвэл бүрэн (газар дээр нь огт очихгүй байх) хэлбэрийн байж болох бөгөөд SFA-ийн Зайнаас

	аудит хийх бодлогод нийцсэн байна. https://sustainablefibre.org/wp-content/uploads/2026/02/SFA-074-01.0-EN-Remote-Auditing-Policy-final-May-2022.pdf
Эрсдэлийн үнэлгээ	а) Тухайн аж ахуйн нэгжээс өөрийн хамрах хүрээний гэрчилгээнд хамаарах бүх салбар нэгжийг харгалзан үзэж SFA-ийн гаргасан схем, загварын дагуу; б) ТҮБ-аас SFA-ийн гаргасан схем, загварын дагуу хийх SFA-ийн стандартын шаардлагыг хангахад амжилтгүй болох эрсдэлийн үнэлгээ.
Магадлан хяналтын үнэлгээ	Аж ахуйн нэгжийн эрсдэлийн түвшинд үндэслэсэн, өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгжийн явцын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх үнэлгээ.
Үнэлгээний мэргэжилтэн	Үнэлгээ хийх чадамжтай хүн.
Баталгаа	Бүтээгдэхүүн, үйл явц, тогтолцоо, хувь хүн эсвэл аж ахуйн нэгжид холбогдолтой тодорхой шаардлагыг хангасан болохыг харуулах нотолгоо (ISEAL).
Баталгааны загвар	Схемийг хэрэгжүүлэх баталгааны үйл ажиллагааны төрөл, эдгээр үйл ажиллагааг зохицуулах, хянах бүтэц болон баталгааны тогтолцоог хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын талаар схем эзэмшигчийн гаргасан шийдвэрээс үүдэлтэй арга барил (ISEAL).
Баталгааны тогтолцоо	Багц шаардлага, дүрэм, журмыг тогтмол хэрэглэн баталгаа гаргах системтэй арга барил (ISEAL).
Аудит	“Үнэлгээ”-г үзнэ үү.
Багц	Багцын дугаар, багцын гэрчилгээ, түүхий эд материалын багц, үйлдвэрлэлийн багц зэрэг дахин давтагдахгүй таних тэмдгээр таних боломжтой бүтээгдэхүүн/үйлдвэрлэлийн материалын салангид бүлэг.
Холих	Өөр өөр ширхэгтийн хослол.
Брэнд	Байгууллага өөрийн нэрээр борлуулах бүтээгдэхүүний загвар, хөгжүүлэлт, худалдан авалтыг хянаж шалгах боломжтой дахин давтагдахгүй таних тэмдэг. Өөрийн нэрээр эсвэл хувийн шошготой борлуулах эцсийн бүтээгдэхүүний загвар, хөгжүүлэлт, худалдан авалтыг зохицуулдаг байгууллагыг мөн хэлнэ. Брэндүүд бөөний худалдаачид, жижиглэн худалдаачид болон хэрэглэгчдэд шууд борлуулж болно.
ТҮБ-ын хяналт	Тодорхой баталгаа болон баталгаажуулалтын үүрэгт ажлыг гүйцэтгэх стандартын болон нийцлийн шаардлагыг Тохирлын үнэлгээний байгууллага үргэлжлүүлэн хангаж буй эсэхэд хийх мониторинг.
Ноолууран ширхэгт	Ноолуурын ямааны үсэн бүрхүүлээс гаргаж авсан тансаг зэрэглэлийн ширхэгт гэж үзэгддэг нарийн, зөөлөн ноос.
Ноолуурын түншлэл	Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээнд SFA-ээр баталгаажсан ноолуур үйлдвэрлэдэг SFA-д бүртгэлтэй бэлтгэн нийлүүлэгчдийг SFA-д бүртгэлтэй худалдан авагчидтай холбох SFA-ийн цахим платформ.

Баталгаажуулалтын Хураангуй Тайлан (БШХТ)	ТҮБ-аас аудит бүрийн дараа аудитын үр дүн, үл тохирол болон баталгаажуулалтын төлөвийн хураангуйг багтаасан SFA-д хүргүүлдэг тусгай тайлан.
Гэрчилгээ	Аливаа зүйлийг чанарын баталгааны үйл явцаар үнэлж, нотолсны үндсэн дээр тодорхой багц шаардлагыг хангаж буй байдлын албан ёсны батламж. Үүнд хамрах хүрээний гэрчилгээ болон гүйлгээний гэрчилгээ багтана. Жишээ нь: а) Мөшгөлтийн тогтолцоо стандартын дагуух хамрах хүрээний гэрчилгээ; б) Малын гаралтай ширхэгт стандартын дагуух Тохирлын гэрчилгээ; в) Цэвэр ноолуур боловсруулах стандартын дагуух Тохирлын гэрчилгээ бүгд нэг ижил гэрчилгээ юм.
Баталгаажуулалт	Аливаа зүйлийг чанарын баталгааны үйл явцаар үнэлж, нотолсны үндсэн дээр тодорхой багц шаардлагыг хангаж буйг гэрчилсэн бичмэл баталгаа гаргах, албан ёсны хараат бус батламжийг (гэрчилгээ) олгох үйл ажиллагаа. Үүнд давтан баталгаажуулалт мөн хамаарна. Практикт бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл тогтолцоо нь тодорхой стандартын шаардлагыг хангаж байгаа байдалд бие даасан баталгаажуулалтын байгууллагаас гаргах бичмэл баталгаа юм. Энэхүү үйл явцын үр дүнд Хамрах хүрээний гэрчилгээг олгоно.
Баталгаажуулалтын төлөв	Баталгаажсан аж ахуйн нэгжийн хамрах хүрээний гэрчилгээ хүчинтэй, түдгэлзсэн эсвэл буцаагдсан эсэх байдал.
Баталгаажуулалтын баг	Гэрчилгээ олгож болох эсэхийг тодорхойлохын тулд нотлох баримт хангалттай эсэх, ТҮБ-ын баталгааны үйл явц зөв хэрэгжиж байгаа эсэхийг магадлан шалгах туршлага, үр чадвартай ТҮБ-ын бие даасан баталгаажуулалтын шийдвэр гаргагчдын баг.
Мөшгөлтийн тогтолцоо (МТ)	Нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрт дамжин шилжиж буй орц, гарц болон холбогдох үзүүлэлтийг дамжуулах, хянах, шалгах замаар SFA-ийн Мөшгөлтийн тогтолцоо стандартын дагуу “SFA Certified” ширхэгтийг биетээр тусгаарлах болон мөшгөх боломжоор хангах арга.
Мэдэгдэл	Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ эсвэл байгууллагын тогтвортой байдлын үзүүлэлтийн талаар сурталчлах мэдээлэл харилцаа. Үүнд гол бүрэлдэхүүн хэсгийн гарал үүсэл, үйлчлүүлэгчийн баталгааны статус болон/эсвэл үйлчлүүлэгчийн схемд холбогдолтой байдал зэрэг мэдээлэл багтана. Тайлбар: Эдгээр мэдээлэл харилцаа нь бизнесээс бизнест эсвэл бизнесээс хэрэглэгчдэд чиглэсэн байж болох бөгөөд мөн үүнийг схем эзэмшигч эсвэл түүний үйлчлүүлэгч хийж болно. Мэдэгдлийг бичвэр, лого, шошго, итгэлцлийн тэмдэг зэрэг төрөл бүрийн мэдээллийн хэрэгслээр хийж болно. (ISEAL Credibility Principles, V2).
“SFA Certified” мэдэгдэл	SFA-ийн стандартыг дурдсан эсвэл эш татсан аливаа мэдэгдэл. Ерөнхий мэдэгдэл эсвэл бүтээгдэхүүний мэдэгдэл байхаас үл хамааран мэдэгдэлд лого ашиглах болон бичвэрт мэдэгдлийн аливаа хослолыг багтааж болно. Гаргаж болох мэдэгдлийн төрөл

	нь зарж борлуулж буй бүтээгдэхүүний мөн чанар болон тухайн мэдэгдлийн баталгааны түвшнээс хамаарна.
Захиалгат мэдэгдэл	Урьдчилан бэлтгээгүй мэдэгдэл. “Нийлүүлсэн мэдэгдэл”-ийг үзнэ үү.
Агууламжийн мэдэгдэл	Бүтээгдэхүүн эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд “SFA Certified” ширхэгт агуулагдах байдал болон/эсвэл тодорхой хувь хэмжээг заасан тухайн бүтээгдэхүүнд хамаарах мэдэгдэл. Агууламжийн мэдэгдэлийг хүчинтэй Борлуулалтын гэрчилгээнд үндэслэх бөгөөд баталгаажсан материалын найрлагыг үнэн зөв тусгах ёстой.
Ерөнхий мэдэгдэл	Ямар нэг бүтээгдэхүүнд хамаарахгүй ерөнхий мэдэгдэл. Ийм мэдэгдэл нь тухайн байгууллага нь SFA-ийн гишүүн, “SFA Certified” ширхэгтийг худалдан авдаг эсвэл SFA-ийн нэг буюу хэд хэдэн стандартаар баталгаажсныг илэрхийлж болно. Ерөнхий мэдэгдлийг байгууллагын үүрэг амлалт, тогтвортой хөгжлийн стратеги, SFA-ийн үйл ажиллагааг танилцуулж буй вэбсайт, үзэсгэлэн худалдааны баннер, зар сурталчилгаа болон/эсвэл каталогт ашиглаж болно. “SFA Certified” логог ерөнхий мэдэгдэлд дагалдуулан ашиглахгүй. Байгууллагын мэдээлэл харилцаанд, гишүүд нь SFA-ийн гишүүнчлэлтэй байснаараа SFA Certified бүтээгдэхүүнийг зарж борлуулна гэсэн ойлголтыг хэрэглэгчдэд төрүүлж болох аливаа мэдэгдлийг хийхгүй. Тайлбар: Жишээг MT стандартад тусгасан болно.
Бүтээгдэхүүний мэдэгдэл	Тодорхой нэг бүтээгдэхүүн “SFA Certified” болохыг ямар нэг байдлаар илэрхийлэх аливаа мэдэгдэл (жишээ нь: баглаа боодлын шошго, зүүдэг шошго, хувцасны шошго, онлайн бүтээгдэхүүний тайлбар, худалдааны маркетингийн цэг гэх мэт). Эдгээр нь зөвхөн эцсийн бүтээгдэхүүнийг хамрах бөгөөд түүгээр хязгаарлагдахгүй. Бүтээгдэхүүний мэдэгдэл нь тодорхой бүтээгдэхүүний сав баглаа боодолд байрлах (хувцасны шошго, зүүдэг шошго) мэдэгдэл болон тодорхой бүтээгдэхүүнийг илэрхийлэх тээврийн баримт бичиг, зар сурталчилгаа, танилцуулга хуудас, брошюр, постер гэх мэт сав баглаа боодлоос бусад мэдэгдэл гэсэн төрөлтэй байна. Тайлбар: Жишээг MT стандартад тусгасан болно.
Тодотгосон мэдэгдэл	Бүтээгдэхүүн дээрх “SFA Certified” гэсэн тэмдэглэгээ бүхий мэдэгдлийг дагалдуулан гаргасан тайлбар, үүнд хэрэглэгчийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор SFA-ийн үйл ажиллагааг тодотгосон мэдээлэл багтана. Тайлбар: Жишээг MT стандартад тусгасан болно.
Урьдчилан бэлтгэсэн мэдэгдэл	ТҮБ-аас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагагүй “SFA Certified” мэдэгдэл.
Байгаль орчны мэдэгдэл	Европын Холбоо эсвэл үндэсний хуулиар шаардаагүй, худалдааны холбоо харилцаанд ямар нэг хэлбэрээр (бичвэр, зураг, шошго, тэмдэгт зэрэг багтана) ашигладаг аливаа мэдээлэл

	эсвэл илэрхийлэл. Энэ нь тухайн бүтээгдэхүүн, брэнд эсвэл арилжаа эрхлэгч нь байгаль орчинд үзүүлэх нөлөөг эерэг, сөрөг нөлөөгүй эсвэл бага хор хөнөөлтэй болон уг нөлөөлөл цаг хугацааны явцад сайжирсан гэдгийг заах буюу илэрхийлнэ (Эх сурвалж: Удирдамж (EU) 2024/825, Удирдамж 2005/29/EC-ийн нэмэлт, Зүйл 2(о)).
Үүрэг амлалт	Худалдаа эрхлэгч байгууллагаас “SFA Certified” ширхэгтийг худалдаалахдаа олон нийтэд зарласан тодорхой хугацаатай үүрэг амлалт. https://sustainablefibre.org/resources/
Мэдэгдлийн зөвшөөрөл	Аж ахуйн нэгж нь зөвшөөрөл шаардлагагүй “Урьдчилан бэлтгэсэн мэдэгдэл”-ээс бусад тохиолдолд ТҮБ-д хүсэлт гаргаж, мэдэгдлийн агуулга нь SFA-ийн Мөшгөлтийн тогтолцоо стандартын мэдэгдлийн шаардлагад нийцэж буй эсэхийг хянуулах, магадлан шалгуулах үйл явц. Зөвшөөрлийг “SFA Certified” мэдэгдэл болон лого ашиглах зөвшөөрлийн маягт ”-ыг ашиглан илгээнэ. SFA Certified Claims and Logo approval form
Чадамж	Тодорхой ажлыг гүйцэтгэх хангалттай мэдлэг, дүгнэлт хийх чадвар, эсвэл үр чадвартай байх чанар.
Гомдол	Хувь хүн эсвэл байгууллагаас SFA-ийн схем, гишүүд эсвэл ТҮБ-ын үйл ажиллагаа, шийдвэр, хандлагатай холбоотойгоор албан ёсны хариу арга хэмжээ авах буюу шийдвэрлэхийг шаардаж гаргасан сэтгэл ханамжгүй байдал эсвэл саналын зөрүүтэй байдлын албан ёсны илэрхийлэл. Хувь хүн эсвэл байгууллагын хандлага, зан төлөв эсвэл шударга бүс журмын талаар байж болох бөгөөд гомдлыг тухайн аж ахуйн нэгж, ТҮБ эсвэл SFA-ээс хэрэгжүүлдэг гомдол шийдвэрлэх албан ёсны журмын дагуу гаргана. Гомдол, санал хүсэлттэй холбоотой дараах холбоосыг ашиглана уу: 1. Санал хүсэлт (англи): https://sustainablefibre.org/consultation/ 2. Гомдол/маргаан шийдвэрлэх журам (англи): https://sustainablefibre.org/wp-content/uploads/2024/07/240801_SFA-Complaints-Disputes-Resolution-Procedure_v2.pdf 3. Гомдол/маргаан шийдвэрлэх журам (Монгол): https://sustainablefibre.org/wp-content/uploads/2024/08/240801_SFA-Complaints-Disputes-Resolution-Procedure_v2_MNG.pdf 4. Гомдол/маргаан шийдвэрлэх журам (Хятад): https://sustainablefibre.org/wp-content/uploads/2024/08/CH-240801_SFA-Complaints-Disputes-Resolution-Procedure_v2.pdf
Үр чадвартай хүн	Зорьсон үр дүнд хүрэх мэдлэг болон үр чадвараа (ТҮБ-д) нотлон харуулж чадах танигдах боломжтой хүн. Энэ чадамжийг бодит үйл ажиллагаагаар харуулах эсвэл бодит үйл ажиллагаагаар харуулах боломжгүй тохиолдолд (жишээлбэл, нядалгааны арга техникийн үр чадамжаа харуулах гэх мэт) онолын хувьд тухайн

	хүний хамрагдсан сургалт болон хүссэн үр дүнд хүрэх туршлагын мэдээллээр нотлон харуулж болно.
Бүрэлдэхүүн хэсэг	Эцсийн бүтээгдэхүүний нэг хэсэг байдлаар оруулсан эсвэл оруулах зорилготой, дахин давтагдахгүй, танигдах боломжтой материал. Бүрэлдэхүүн хэсгийг хэрэглэгчид бэлэн бүтээгдэхүүн дээр хялбархан таних боломжтой байдаг.
Тохирол	Стандартын эсвэл гүйцэтгэлийн шаардлагыг бүрэн хангасан болохыг харуулах нотолгоо (ISEAL/ISO).
Ашиг сонирхлын зөрчил	Хувь хүн эсвэл байгууллагын шударга байдал болон мэргэжлийн үүрэг хариуцлага нь бодитоор алдагдсан, алдагдаж болзошгүй эсвэл алдагдсан мэт харагдах аливаа нөхцөл байдал. Иймд ашиг сонирхлын зөрчил нь бодит, боломжит эсвэл таамагласан байж болно (ISEAL).
Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)	Тохирлын үнэлгээний үйл ажиллагааг гүйцэтгэх чадамж, найдвартай байдал, хараат бус байдал болон нэгдмэл байдал нь Олон улсын итгэмжлэлийн форум (IAF)-ын Олон талт хэлэлцээрт (MLA) нэгдэн орсон Итгэмжлэлийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага.
Тохирлын тэмдэг ашиглах зөвшөөрөл	“SFA-ийн батламжилсан” ТҮБ-аас шаардлагад нийцсэн нийлүүлэлтийн сүлжээний оролцогчдод “SFA Certified” логог тодорхой бүтээгдэхүүн дээр тогтоосон зорилгоор (жишээлбэл, зүүдэг шошго, сурталчилгааны материал эсвэл албан харилцаанд ашиглах) хэрэглэхэд олгодог зөвшөөрөл.
Зөвшилцөл	Аливаа гол оролцогч талууд тухайн асуудлаар ноцтой эсэргүүцэл үзүүлэхгүй байдалд хүрсэн нийтлэг тохиролцоо. Тайлбар: Зөвшилцөл нь сонирхогч талууд, ялангуяа шууд нөлөөлөлд өртөж буй талуудын санал бодлыг харгалзан үзэж, зөрчилтэй аливаа асуудлыг шийдвэрлэх үйл явцын үр дүн байвал зохино. Энэ нь бүгд санал нэгтэй байна гэсэн үг биш, харин асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой шийдэлд хүрснийг илэрхийлнэ.
Хэрэглэгч	Хувийн хэрэгцээнд зориулан бараа, үйлчилгээ худалдан авдаг хувь хүн эсвэл бүлэг.
Агууламжийн мэдэгдлийн стандарт	SFA-ийн Мөшгөлтийн тогтолцоо стандартад дүйцэхүйц гэж хүлээн зөвшөөрөгдсөн Textile Exchange байгууллагын хэрэгжүүлдэг Мөшгөлтийн тогтолцооны стандарт. Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү.
Тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөө (ТСТ)	SFA-ийн Малын гаралтай ширхэгт стандартын 7.2-т заасан шаардлагыг хангах зорилгоор бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас боловсруулж, хэрэгжүүлдэг төлөвлөгөө.
Хөрвүүлэгч фактор	Тодорхой төрлийн боловсруулалтын явцад бүтээгдэхүүнд нэмэгдэх эсвэл алдагдах хэмжээг ойролцоогоор тооцоолох тогтмол утга.
Бодит хөрвүүлэгч фактор	Тодорхой төрлийн боловсруулалтыг бүтээгдэхүүний тодорхой нэг багцад хийсний үр дүнд боловсруулагчийн ажигласан хөрвүүлэгч фактор.
Таамагласан хөрвүүлэгч фактор	Тодорхой төрлийн боловсруулалтад боловсруулалт эхлэхээс өмнө ТҮБ-тай урьдчилан тохиролцож хэрэглэдэг стандартчилсан эсвэл урьдчилан тооцоолсон хөрвүүлэх фактор. Таамагласан хөрвүүлэх

	фактор нь аж ахуйн нэгжийн дараагийн хамрах хүрээний аудит хүртэл эсвэл боловсруулалтын үйл явцад мэдэгдэхүйц өөрчлөлт орох хүртэл хүчинтэй хэвээр байна.
Залруулах арга хэмжээ	Үл тохирол эсвэл бусад хүсээгүй нөхцөл байдлын шалтгааныг арилгах болон дахин давтагдахаас сэргийлэх зорилгоор авсан арга хэмжээ (ISEAL).
Хялгасыг ялгасан [ширхэгт/ноолуур]	Угааж цэвэрлэсэн (ө.х. угаасан) бөгөөд хялгасыг ялгасан (ө.х. илүүдэл хялгасыг салгасан) ширхэгт.
Түр зохицуулалт	Тодорхой шаардлагыг өөрөөр хэрэглэх эсвэл огт хэрэглэхгүй байх боломж олгодог түр хугацааны норматив арга хэмжээ. Түр зохицуулалтыг тухайн стандартын дараагийн төлөвлөгөөт хяналтын дараа хэрэглэх боломжгүй бөгөөд үүгээр түр зохицуулалт нь хүчингүй болох эсвэл SFA-ийн Стандарт боловсруулах журмын дагуу албан ёсны шинэчлэл болно.
Маргаан	Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн (жишээ нь санал гомдол, зөрчлийн гомдол).
Маргаан шийдвэрлэх тогтолцоо	Хувь хүмүүс, сонирхол нэгт иргэдийн бүлэг эсвэл байгууллага нь схем эзэмшигч, баталгаа гаргагч болон хяналтын байгууллагад санал гомдол болон зөрчлийн гомдол гаргах болон шийдвэрлүүлэх боломж олгодог механизм. SFA-ийн хувьд энэ тогтолцоо нь хамтын оролцоотой, шийдэлд суурилсан болон хэт албаны бус аргыг ашиглах бүтэцтэй байдаг. https://sustainablefibre.org/wp-content/uploads/2024/07/240801_SFA-Complaints-Disputes-Resolution-Procedure_v2.pdf
Магадалгаа	Байгууллага нь өөрийн үйл ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээ болон бизнесийн бусад харилцаанд учирч буй бодит болон болзошгүй сөрөг нөлөөллийг хэрхэн шийдвэрлэхээ тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах болон тооцоолох үйл явц (ЭЗХАХБ-Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага). Магадалгаа нь эрсдэлд суурилсан, байнгын, сэргийлэх болон засан залруулах зорилготой бөгөөд хүний эрх, хөдөлмөрийн эрх, байгаль орчин, авлига ба хээл хахуул, хэрэглэгчийн эрх ашиг, корпорацийн засаглал зэрэгт хэрэглэгддэг.
Будах	Шаардлагатай өнгөний тогтворжилт бүхий өнгийг бий болгох зорилгоор ширхэгт, утас, даавуу зэрэг нэхмэлийн материалд будагч бодис эсвэл пигмент хэрэглэх үйл явц.
Хүчин төгөлдөр мөрдөгдөх огноо (Стандартын)	Өмнө нь стандартын дагуу баталгаажилт хийлгэж байгаагүй аж ахуйн нэгжийн үнэлгээг уг стандартын тодорхой нэг хувилбарын дагуу хийж эхлэх огноо.
Аж ахуйн нэгж	Үнэлгээнд хамрагдах эрхтэй, хамрах хүрээний гэрчилгээтэй болон нийцлийн үүрэг хариуцлага хүлээгч гэж үзэгдэх хууль ёсны бүртгэлтэй байгууллага эсвэл хувь хүн. Аж ахуйн нэгж нь газарзүйн хувьд нэг буюу хэд хэдэн тусдаа салбар нэгжийг хамарч болно. Аж ахуйн нэгж нь дараах хэлбэртэй байж болно: а) SFA-ийн Малын гаралтай ширхэгт стандартын хамрах хүрээнд бэлтгэн нийлүүлэгч,

	b) SFA-ийн Цэвэр ноолуур боловсруулах стандартын хамрах хүрээнд хялгасыг ялгах болон/эсвэл угаах үйлдвэр. Аж ахуйн нэгжид хувь малчин өрхүүд/байгууллагууд, фермерүүд, фермерийн бүлгүүд, бэлтгэн нийлүүлэгч байгууллага, худалдаа эрхлэгчид, ширхэгт боловсруулах үйлдвэрүүд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиглэн худалдаачид багтаж болно. Жишээлбэл: a) Монголын Бэлтгэн нийлүүлэгч байгууллага нь удирдлагын оффис болон хамрах хүрээний гэрчилгээнд багтсан бүртгэлтэй олон тооны бэлтгэн нийлүүлэгч өрхүүд (нэгж)-ээс бүрдэх аж ахуйн нэгж. b) Худалдан авалтын төв нь удирдлагын оффис болон хамрах хүрээний гэрчилгээнд багтсан олон тооны бэлтгэн нийлүүлэгч фермүүд (нэгж)-ээс бүрдэх аж ахуйн нэгж. Тайлбар: Зарим аж ахуйн нэгж Монголын хэд хэдэн сумыг хамарч болно.
Ферм	Задгай бэлчээр болон хамгаалалттай байр хослуулан ашигладаг хашаалсан мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо.
Эцсийн төлөв (ширхэгтийн)	Тухайн багц ширхэгтээс гарах эцсийн үр дүн.
Ширхэгт ургуулдаг амьтан	“SFA Certified” гэж худалдах боломжтой байгалийн ширхэгтийг ургуулдаг амьтан. Одоогийн байдлаар үүнд ноолуурын ямаа багтана.
Эцсийн бүтээгдэхүүн	Одоо байгаа байдлаар нь нэмэлт боловсруулалтгүйгээр хэрэглэгчид борлуулах бэлэн бүтээгдэхүүн. Эцсийн бүтээгдэхүүн нь эцсийн хэрэглэгчдэд хүрэхээс өмнө бизнесээс бизнес рүү (жишээлбэл, эцсийн үйлдвэрлэгчээс брэнд рүү) худалдаалагдаж болно.
Малын тэжээл	Амьтанд өгөхөөр хураан авсан тэжээл.
Тэжээлийн ургамал	Газар дээр амьд ургаж байх үед нь амьтан олж иддэг тэжээл.
Давтагдашгүй хүчин зүйлс	Гэрээний үүргийг биелүүлэхэд саад учруулах эсвэл гэрээ/хэлэлцээр хэрэгжихгүйд хүргэх урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал. Жишээлбэл дайн, гэмт хэрэг, газар хөдлөлт зэрэг гэнэтийн үйл явдал нь хэн нэгнийг хууль ёсны гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд саад учруулдаг.
Түүхий ширхэгт/ноолуур	Хараахан угаагдаагүй ширхэгт.
Самнаж бэлтгэх	Амьтнаас ширхэгт/ноолуурыг салгах үйл явц.
Самнаж бэлтгэх улирал	Хоёр өвлийн улирлын хооронд амьтнаас ширхэгтийг салган бэлтгэж авах хугацаа.
Малчин / Малчин өрх	Нийтийн бэлчээрт ноолуурын ямаа зэрэг мал малладаг гэр бүл. Тайлбар: Монголд мал өсгөх, маллах олон үйл ажиллагааг бусад хүмүүстэй хамтран хийдэг тул мал аж ахуйн үйл ажиллагааны нэгж нь нэг малчин өрхөөр хязгаарлагдахгүй байх боломжтой.

Малчны байгууллага	“Бэлтгэн нийлүүлэгч байгууллага”-ыг үзнэ үү.
Үйлдвэрийн байгууламж	Боловсруулалт хийгддэг механикжсан үйлдвэр.
Үр нөлөө	Схемийг хэрэгжүүлсний үр дүнд гарч буй урт хугацааны, том хэмжээний өөрчлөлт. Зорилтот үр нөлөө гэдэг нь схем эзэмшигч өөрийн схемээр дамжуулан бий болгохоор зорьж буй урт хугацааны, том хэмжээний өөрчлөлт юм (ISEAL).
Шударга байдал	Схем, схемийн хэрэгжүүлэлт болон түүний шийдвэр гаргах байгууллагад зарчимч чанар байгаагийн илрэл. Зарчимч чанар гэдэг нь аливаа нэг нөлөөлөлд автахгүй байх, мөн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг хэлнэ (ISEAL).
Үзүүлэлт	Өөрчлөлт болон гүйцэтгэлийг хянаж ойлгох боломжийг олгох тоон болон чанарын хүчин зүйл эсвэл сонгогдсон хувьсагч. Үзүүлэлт нь схем, түүнийг хэрэглэгч, схем эсвэл хэрэглэгчийн гүйцэтгэл эсвэл үр дүн эсвэл тэдгээрийн ажиллагаа явуулдаг чиглэлтэй холбоотой байж болно (ISEAL).
Сайжруулалтын үзүүлэлт	Стандартад шаардлага (байх ёстой) болон сайжруулалтын үзүүлэлт (байх боломжтой) гэсэн заалтууд байдаг. Сайжруулалтын үзүүлэлт нь “байх боломжтой” гэсэн үгээр илэрхийлсэн шаардлага юм.
Мэдээллийн Удирдлагын Тогтолцоо (МУТ)	Мэдээлэл, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, цуглуулах, хадгалах, зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, түгээх зорилготой журам, үйл явц болон бүтэц.
Орц	Мөшгөлтийн тогтолцооны бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэгддэг бүх бодис, материал. Мөн худалдан авсан “SFA Certified” бүтээгдэхүүний тоо хэмжээг хэлнэ.
Дотоод Удирдлагын Тогтолцоо (ДУТ)	Тогтоосон шаардлага, зорилгодоо хүрэхийн тулд тухайн бүлгийн хэрэгжүүлдэг баримтжуулсан багц бодлого, үйл явц. Дотоод удирдлагын системтэй байх нь баталгаа гаргагч тухайн бүлгийн гишүүн нэг бүрийн хяналтыг бүлгийн доторх тогтоосон нэгжид хариуцуулан шилжүүлэх боломж олгоно. Дотоод удирдлагын тогтолцоонд Чанарын удирдлагын тогтолцоо (ЧУТ) багтаж болно.
Нэхэх	Үргэлжилсэн утас эсвэл багц утсыг ашиглан хоорондоо холбоотой дараалласан гогцоо үүсгэх даавууны үйлдвэрлэл.
Зөвшөөрлийн гэрээ	SFA болон нийлүүлэлтийн сүлжээний нийцлийг хангасан оролцогчийн хооронд “SFA Certified” логот ашиглах эрхийг олгох зорилгоор байгуулсан гэрээ.
Удирдлагын оффис	Аж ахуйн нэгжийн төв оффис. Оффис нь виртуал байж болох ч бодит хаягтай холбогдсон байх ёстой.
Үйлдвэрлэл	Захиалгат бүтээгдэхүүн эсвэл бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийг бий болгох боловсруулалт. Үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж/боловсруулагчийг үйлдвэрлэгч гэнэ.
Сар бүрийн баталгаажуулалтын мэдээ (СБМ)	ТҮБ-аас өмнөх сарын баталгаажуулалтын үйл ажиллагааны талаар SFA-д өгдөг сар бүрийн тайлан.
Сарын бүрийн гүйлгээний мэдээ (СГМ)	SFA-ийн Баталгаа ба Баталгаажуулалтын гарын авлагын 35.1-р заалтын дагуу өмнөх тайлант хугацаанд олгосон борлуулалтын гэрчилгээг тайлагнах зорилгоор ТҮБ-д олгосон маягт.

Холих	Баталгаажсан болон баталгаажаагүй ширхэгтийн хослол.
Мониторинг, үнэлгээ ба хөгжүүлэлт (тогтолцоо) (МҮХ)	Удирдлага болон бусад оролцогч талуудад ахиц дэвшил, сайжруулалтын цар хүрээ, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байдал, төлөвлөөгүй үр дагавар эсвэл хэрэгжилтэд тулгарч буй асуудал, тодорхой хөгжүүлэлтэд тавигдах асуултуудын хариултууд, тасралтгүй сайжруулалтыг дэмжих сургамжийг харуулах зорилгоор өгөгдөл, мэдээллийг системтэйгээр цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх ажлыг хамруулсан харилцан уялдаатай үйл ажиллагаа, үйл явц болон арга хэмжээ.
Байгалийн ширхэгт	Бүтээгдэхүүн (жишээ нь: нэхмэл эдлэл, тавилга, цаас)-д бүрэлдэхүүн хэсэг болгон ашигладаг ургамал эсвэл амьтнаас цуглуулж авдаг үстэй төстэй түүхий эд.
Үл тохирол	Стандартын эсвэл холбогдох баталгаажуулалтын журмын тодорхой шаардлагыг хангаагүй, эсвэл биелүүлээгүй байдал. Дэлгэрэнгүй мэдээллийг SFA-ийн Баталгаа ба баталгаажуулалтын гарын авлагаас үзнэ үү.
Норматив баримт бичиг	Үйл ажиллагаа болон түүний үр дүнд хамаарах дүрэм, заавар буюу онцлогийг тодорхойлсон заавал мөрдөх баримт бичиг.
Үр дагавар	Схем эсвэл түүний тодорхой хэсгээс үүдэн бий болсон богино болон дунд хугацааны үр дагавар буюу өөрчлөлт (ISEAL).
Гарц	Схем эсвэл түүний тодорхой хэсгийн үйл ажиллагаанаас үүдэн шууд бий болсон бүтээгдэхүүн, хөрөнгийн хэрэгсэл эсвэл үйлчилгээ (ISEAL). Мөн SFA-ийн Мөшгөлтийн тогтолцоо стандартын хүрээнд гарц нь “SFA Certified” бүтээгдэхүүний нөөц, “SFA Certified” гэж борлуулсан бүтээгдэхүүн, баталгаажаагүй гэж борлуулсан бүтээгдэхүүн, боловсруулах явцад хаягдал гэж хаясан буюу бусад байдлаар хаясан/буцаагдсан бүтээгдэхүүнийг хамарна.
Гарцын хүчин чадал	Тухайн салбар нэгжийн хэвийн үедээ үйлдвэрлэвэл зохих ширхэгтийн хүлээгдэж буй хэмжээ.
Гэрээгээр гүйцэтгүүлэх	Гуравдагч этгээдээс гэрээний дагуу бараа, үйлчилгээг авах. Практикт энэ нь “SFA Certified” материалыг тодорхой үйлчилгээ авах зорилгоор туслан гүйцэтгэгчид шилжүүлэн өгөх үйл явц юм.
Хяналт	Баталгаа гаргагч тодорхой баталгаа гаргах үйл ажиллагааг гүйцэтгэх чадамжтай, шударга, тууштай байгаа эсэхийг хянах үүрэг хариуцлага.
Хяналтын байгууллага (ХБ)	Баталгаа гаргагчийн гүйцэтгэлийг үнэлэх байгууллага (ISEAL). Тайлбар: Энэ нь итгэмжлэлийн байгууллага байж болно.
Хяналтын механизм	Баталгаа гаргагчийг үнэлэх боломжийг олгодог шаардлага, дүрэм болон журам (ISEAL).
Хослуулах	Өөр өөр шинж чанартай хоёр тусдаа утасны хослол.
Анхан шатны боловсруулагч	Түүхий ширхэгтийг ангилах, угааж цэвэрлэх болон/эсвэл хялгасыг ялгахад оролцдог боловсруулагч.
Боловсруулалт	Хими, физик, механикийн болон бусад технологийн аргаар түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн эсвэл хагас боловсруулсан бүтээгдэхүүн болгон хувиргах багц үйл ажиллагаа.
Боловсруулалтын бүртгэл	Боловсруулалт болон/эсвэл чийгшүүлэлт хийж байгаа бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан баримт бичиг.

	ТҮБ нь бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг зөвшөөрснөөр бүртгэлийн баримт хүчин төгөлдөр болно.
Боловсруулагч	Боловсруулалт хийдэг аж ахуйн нэгж.
Бүтээгдэхүүн	Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор бий болгосон аливаа бараа, үйлчилгээ эсвэл дижитал шийдэл. Энэ нь биет болон биет бус хэлбэртэй байж болох бөгөөд зах зээл дээр ихэвчлэн тодорхой үнэ өртгөөр арилжаалагддаг.
Бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж	Түүхий ширхэгтийг үйлдвэрлэх болон/эсвэл бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж эсвэл аж ахуйн нэгжийн гишүүн. Үүнд малчид болон фермерүүд багтана.
Бэлтгэн нийлүүлэгч байгууллага	Тодорхой нутаг дэвсгэрт амьдардаг малчин өрхүүдээс бүрдсэн нийгмийн бүлэг. Үүнд Малчдын хоршоо, Малчны байгууллага, ТББ зэрэг Монгол Улсын Засгийн газраас хуулиар хүлээн зөвшөөрсөн албан ёсны аж ахуйн нэгж болон нутгийн иргэдэд түшиглэсэн байгууллага, Нутгийн иргэдэд түшиглэсэн Бэлчээрийн менежментийн бүлэг зэрэг албан бус аж ахуйн нэгжүүд болон бусад төрлийн албан бус байгууллага багтана.
Төлөөллийн итгэмжлэл	Схем эзэмшигчийн зүгээс хэрэгжүүлдэг хяналтын төрөл, үүнд баталгааны чанарыг харуулахад өөр схемийн хяналтын механизмыг хүлээн зөвшөөрөх нь тодорхой хэмжээнд хангалттай гэж үзнэ (ISEAL).
Олон нийтийн хэлэлцүүлэг	Хүн бүрт нээлттэй хэлэлцүүлэг.
Олон нийтэд зориулсан хураангуй	“Зорилгоо илэрхийлэх мэдэгдэл”-ийг үзнэ үү.
Олон нийтэд нээлттэй байдал	Аливаа хүн саад бэрхшээлгүй хандан авах боломжтой байдал.
Стандартыг нийтэлсэн огноо	Тухайн стандартыг албан ёсоор нийтлэгдсэн огноо.
Баталгаажсан ширхэгтийн жин	Бүтээгдэхүүний баталгаажсан жинг тооцохдоо хуурай жин дээр стандарт чийгийн хэмжээг нэмнэ (ө.х чийгшүүлэлт хийгдсэн жин). Стандарт чийгийн хэмжээг худалдан авагч болон худалдагч талууд тохиролцоно. Баталгаажсан жин нь боловсруулах явцад өөрчлөгдөж болно.
Ширхэгтийн нийт жин	Аливаа сав баглаа боодлын жинг багтаасан бүтээгдэхүүний жин.
Ширхэгтийн цэвэр жин	Аливаа сав баглаа боодлын жин ороогүй бүтээгдэхүүний жин.
Тоо хэмжээг тохируулах тооцоолол	Хөрвүүлэгч факторыг харгалзан гарцын хэмжээ нь орцын хэмжээтэйгээ тогтмол тохирч байгааг хянах (салбар нэгжийн түвшинд) байнгын тооцоолол. Практикт энэ нь худалдан авсан, тухайн салбар нэгжид байгаа болон борлуулсан материалын жин хэмжээг баримтжуулж, хянах байнгын үйл явц бөгөөд “SFA Certified” бүтээгдэхүүний гарцын хэмжээ орцын хэмжээтэй тогтмол тохирч байгааг хянахын тулд холбогдох хөрвүүлэгч факторыг алдаагүй тооцоолно.
Түүхий эд [ширхэгт/ноолуур]	Самнаж бэлтгэсний дараа аливаа нэг боловсруулалт хийгээгүй ширхэгт/ноолуур

Бүртгэл	Стандартын шаардлагыг хангаж байгааг нотлон харуулах зорилгоор хэрэглэгчийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг баримтжуулах мэдээлэл.
Нэхмэлийг дахин боловсруулах	Ширхэгт, утас эсвэл даавууг дахин сэргээх болон материалыг шинэ, хэрэгцээт бүтээгдэхүүн болгон дахин боловсруулах үйл явц.
Бүртгэлтэй тал/талууд	SFA-ийн схемийн хүрээнд бүртгэгдсэн бэлтгэн нийлүүлэгч байгууллага, ширхэгтийн худалдаа эрхэлдэг компани эсвэл ширхэгт боловсруулах үйлдвэр.
Бүртгэл	SFA-ийн нэг ба хэд хэдэн стандартын шаардлагыг хангах зорилготой аж ахуйн нэгжийн албан ёсны үүрэг амлалт бөгөөд SFA-ийн бүртгэлийн маягтыг бөглөж, SFA-ийн бүртгэлийн дугаар олгогдсоноор хэрэгжиж эхэлдэг.
Бүртгэлийн гэрчилгээ	SFA-д бүртгэлтэй байгууллагын гишүүнчлэл нь гэрчилгээ дээрх хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр болохыг тухайн бүртгэлтэй аж ахуй нэгжийн ТҮБ-д нотлон харуулах зорилгоор олгосон гэрчилгээ. Энэхүү гэрчилгээ нь тогтвортой байдлын мэдэгдлийг нотлох эсвэл SFA-ээр баталгаажсан бүтээгдэхүүний баталгаажуулалтыг илэрхийлэхэд ашиглахгүй.
Бүртгэлийн схемийн гарын авлага	Бүртгэлийн схемийн тодорхой хэсэгт хамаарах мэдээллийн баримт бичиг.
Бүртгэлийн үйлчилгээ	SFA-ээс бүртгэлтэй талуудад үзүүлдэг үйлчилгээ.
Шаардлага	Стандарт, техникийн нөхцөл зэрэг норматив баримт бичигт заагдсан хэрэгцээ эсвэл хүлээлт. Стандартын (SFA-ийн стандарт гэх мэт) дагуу гэрчилгээ олгохын тулд бүгдийг нь заавал биелүүлэх ёстой багц шалгуур. Хэрэв тухайн шалгуурын заалтад “байх ёстой” эсвэл “на4” гэсэн бол шаардлагыг норматив (заавал) гэж тодорхойлно.
Үр дүн	Схемийг хэрэгжүүлснээр бий болох гарц, үр дагавар, үр нөлөө (зорьсон эсвэл санамсаргүй бий болсон, эерэг эсвэл сөрөг).
Үр дүнгийн үзүүлэлтийн (ҮДҮ) тайлан	Малчин/фермерийн төлөөллийн бүлгээс түүвэрлэсэн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн мэдээллийг жил бүр цуглуулах үйл явц. Үр дүнгийн үзүүлэлтүүд нь SFA-д итгэмжлэгдсэн малчид болон тухайн нэг ижил бүс нутагт байгаа SFA-ийн хөтөлбөрт хамрагдаагүй бусад малчдын хоорондын ялгааг тоон байдлаар хэмжихэд ашиглагдаж болно.
Жижиглэн худалдааны салбар нэгж	Жижиглэн худалдаа эрхлэгчид бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд борлуулдаг салбар нэгж.
Жижиглэн худалдаа эрхлэгч	Эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд борлуулдаг аж ахуйн нэгж.
Дахин хянах	Тухайн элементийг шинэчлэх шаардлагатай эсэхийг тодорхойлдог схемийн элементийн үнэлгээ. Тайлбар: Дахин хяналтаар тухайн элементийн ач холбогдол хэвээр байгаа байдал, үр ашигтай байдал, хүчинтэй байдал эсвэл тохиромжтой байдлыг үнэлж болно.
Дахин хяналт	Схем, түүний бүрэлдэхүүн хэсэг эсвэл элементийг шинэчлэх үйл явц.

Эрсдэл	Зорилтод нөлөөлөхүйц ямар нэг зүйл тохиолдох магадлал. Үүнийг тухайн тохиолдлын магадлал болон түүний үр дагаврын хослолын хэмжээгээр тодорхойлно (ISEAL).
Эрсдэлийн менежмент	Сөрөг нөлөөллийг дангаар нь болон нийтээр нь ойлгох, удирдан зохицуулах замаар эрсдэлийг хүлээн зөвшөөрөхүйц түвшинд хүртэл бууруулах эсвэл багасгах боломж олгодог үйл явц.
Эрсдэлийг бууруулах	Эрсдэлтэй холбоотой магадлал болон/эсвэл сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ.
Хамгаалалтын бодлого	Эмзэг, өртөмтгий нийгмийн бүлгүүд, хувь хүн, орон нутгийн иргэд болон оролцогч талуудыг аливаа ялгаварлан гадуурхалт, хор хөнөөл эсвэл сөрөг нөлөөллөөс хамгаалах шаардлагыг тодорхойлсон журам эсвэл үйл явц.
Түүвэрлэлтийн төлөвлөгөө	Түүвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэх зорилго, арга зүй (жишээлбэл: санамсаргүй, шаталсан), үндэслэл болон хязгаарлалтыг тодорхойлсон төлөвлөгөө.
Түүвэрлэлтийн стратеги (Түүвэрлэх протокол гэж мөн хэлж болно)	Тухайн авч үзэж буй тогтолцоо, бүтээгдэхүүн эсвэл үйл явцыг хангалттай төлөөлөхөд шаардлагатай түүврийн хэмжээний цар хүрээ болон шинж чанарыг тодорхойлох бодлого эсвэл журам. Үүнийг стандарт эсвэл тогтолцооны шаардлагын дагуу гүйцэтгэл болон нийцлийг үнэлэхэд ашиглана. Протокол нь үнэлгээнд шаардагдах зохистой түүврийн хэмжээг тогтооход харгалзан үзэх эсвэл ашиглах бүх хүчин зүйлсийг тодорхойлно.
Схем/тогтолцоо	Байгууллага эсвэл бүлэг байгууллагаас дараах зорилгоор хэрэгжүүлэх нэгдмэл багц шийдвэр, стратеги. Үүнд: • нэг буюу хэд хэдэн тогтвортой байдлын асуудалд чиглэсэн стандарт эсвэл түүнтэй адил хэрэгслийг бий болгох • эдгээр хэрэгслийн дагуу гүйцэтгэл эсвэл ахиц дэвшлийг хэмжих, хянах эсвэл нотлох • мэдэгдэл гаргах боломжийг олгох Тайлбар: Схем/тогтолцоо нь мөн тогтвортой байдлын үр дагавар болон үр нөлөөг бий болгоход хувь нэмэр оруулах нэмэлт стратегийг (жишээлбэл, чадавх бэхжүүлэх эсвэл нөлөөллийн ажил) хэрэгжүүлж болно.
Схем/тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг	Стандартын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг гэж мөн хэлж болно. Схемийн тодорхойлсон тогтвортой байдлын зорилтот үр дагаварт хүрэхэд хувь нэмэр оруулдаг эсвэл схемийн хяналттай мэдэгдэл болон үр дүнгийн талаар гаргасан мэдээллийг дэмждэг үйл ажиллагааны (ихэвчлэн тогтолцоо, үйл явц, эсвэл нэгж хэсгийг төлөөлөх) дэд хэсгүүд. Схемийн үндсэн бүрэлдэхүүн хэсэгт стандарт тогтоох; мониторинг, үнэлгээ ба хөгжүүлэлт (МҮХ); баталгаа; болон мэдэгдэл багтана.
Схем/тогтолцоо эзэмшигч	Стандартын тогтолцоо эзэмшигч гэж мөн хэлж болно. Стандарт эсвэл гүйцэтгэлийн шаардлагыг хариуцдаг, мөн баталгаа, мэдэгдлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдлыг тооцдог хууль ёсоор байгуулагдсан байгууллага. Схем эзэмшигч нь схемийн зорилго, цар хүрээ, түүнчлэн схем хэрхэн хэрэгжих дүрмийг тодорхойлно.

Схем/тогтолцооны гүйцэтгэл	Схемийн тогтвортой байдлын зорилтот үр дагавар болон үр нөлөөнд схемийн оруулах хувь нэмэр (ISEAL).
Хамрах хүрээний гэрчилгээ	Тухайн байгууллага холбогдох стандартын дагуу нэрлэсэн “SFA Certified” материалыг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, худалдах чадавхтай болохыг ТҮБ-аас нотолж олгодог цахим баримт бичиг. Энэ нь тухайн аж ахуйн нэгжийг SFA-ийн мөшгөх тогтолцоонд оролцох эрхтэй болохыг дараах байдлаар батална. Үүнд: - аж ахуйн нэгжийн нэр, хаяг болон SFA-ийн бүртгэлийн дугаар; - холбогдох стандартын нэр болон хувилбарын дугаар; - олгосон байгууллагын нэр болон гарын үсэг; - олгосон огноо болон дуусах хугацаа; “SFA Certified” ширхэгтийг бэлтгэн нийлүүлсэн, боловсруулсан, хадгалсан, хэрэглэсэн эсвэл худалдсан зэрэг батлагдсан үйл ажиллагааг эрхэлдэг бүх салбар нэгжийн жагсаалт, үүнд туслан гүйцэтгэгчид багтана.
Түдгэлзүүлсэн хамрах хүрээний гэрчилгээ	Тухайн асуудлыг шалгаж дуусах эсвэл асуудал бүрэн хаагдах хүртэл түр хугацаагаар түдгэлзүүлсэн хамрах хүрээний гэрчилгээ.
Хүчингүй болгосон хамрах хүрээний гэрчилгээ	Хугацаа дууссанаас өөр бусад шалтгаанаар хүчингүй болсон хамрах хүрээний гэрчилгээ.
Гэрчилгээний хамрах хүрээ	Хамрах хүрээний гэрчилгээнд хамаарах баталгаажсан бүтээгдэхүүн, боловсруулалт/үйл явц, үйлчилгээ болон/эсвэл удирдлагын тогтолцоо.
SFA-ийн хөтөлбөрийн хамрах хүрээ	SFA-ийн стандартад хамрагдсан бүтээгдэхүүн, боловсруулалт/үйл явц, үйлчилгээ болон удирдлагын тогтолцооны цар хүрээ.
Хоёрдогч (гүн) боловсруулагч	Будах, ээрэх, нэхэх, сүлжих болон/эсвэл бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг боловсруулагчдийн нэгдмэл нэр томьёо.
Өөрийн үнэлгээ	Стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг тогтоох зорилгоор хийдэг дотоод үнэлгээ. Өөрийн үнэлгээг баталгаажуулалт гэж тооцохгүй. SFA-ийн нийцлийн тогтолцоонд өөрийн үнэлгээний хоёр төрөл байдаг. Үүнд: а) Салбар нэгжийн түвшний өөрийн үнэлгээ – тухайн салбар нь SFA-ийн гаргасан загварт үндэслэн өөрийн гүйцэтгэл болон SFA-ийн стандартын нийцлийг үнэлэх; б) Аж ахуйн нэгжийн түвшний өөрийн үнэлгээ – аж ахуйн нэгж нь SFA-ийн гаргасан загварт үндэслэн хамрах хүрээний гэрчилгээнд хамрагдсан малчин, малчин өрх, салбаруудын нэгдмэл гүйцэтгэл болон SFA-ийн стандартын нийцлийг үнэлэх.
Тусгаарлах	“SFA Certified” биет ширхэгтийг баталгаажаагүй ноолуураас байнга бодитоор салгах явдал.
SFA-ийн гүйцэтгэх засаглал	“SFA-ийн Захиргааны нэгж”-ийг үзнэ үү.
SFA-ийн гишүүн	Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (SFA)-д жил бүр гишүүнчлэлийн хураамж төлж, гишүүнчлэлийн үр ашиг хүртэхдээ жинхэнэ гишүүн, дэмжигч гишүүн болон хамтрагч гишүүний

	хувиар гишүүнчлэлийн нөхцөл, шаардлагыг дагаж мөрдөхийг зөвшөөрсөн хувь хүн эсвэл байгууллага.
SFA-ийн хамтрагч гишүүн	Хязгаарлагдмал эрх бүхий гишүүнчлэлтэй хувь хүн, байгууллага болон бүлэг. Зөвхөн хандивлагч байгууллага, ашгийн бус байгууллага болон боловсролын байгууллага байна.
SFA-ийн жинхэнэ гишүүн	SFA-ийн жилийн гишүүнчлэлтэй хувь хүн, байгууллага эсвэл бүлэг.
SFA -ийн дэмжигч гишүүн	SFA-ийн бүртгэлтэй гишүүнээр 12 сарын туршилтын хугацааны гишүүнчлэлтэй хувь хүн, байгууллага болон бүлэг. Дэмжигч гишүүн нь SFA-ээр баталгаажсан ширхэгтийг худалдах мэдэгдэл гаргах боломжгүй.
SFA-ийн норматив баримт бичиг	SFA-ийн стандартын шаардлага, SFA-ийн стандартын баталгаа ба баталгаажуулалтын шаардлага эсвэл үнэлгээний удирдамж.
SFA-ийн бүртгэл	SFA-д бүртгэгдсэн малчдын байгууллагууд болон анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийн цахим мэдээллийн сан. Бүртгэл нь SFA-ийн нэг эсвэл хэд хэдэн стандартын шаардлагын дагуу үнэлгээнд хамрагдах үүргийн амлалтыг илэрхийлнэ. SFA-д бүртгэлтэй боловсруулагч нь мөн SFA-ийн гишүүн байж болох боловч үүнийг заавал шаардахгүй. Харин SFA-д бүртгэлтэй малчид нь SFA-ийн гишүүн байх боломжгүй.
SFA-ийн бүртгэлийн схем	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд, худалдаа эрхлэгчид болон боловсруулах үйлдвэрүүдийг бүртгэхэд SFA-ээс хэрэгжүүлдэг бүртгэлийн схем.
SFA-ийн Захиргааны нэгж	SFA-ийн Гүйцэтгэх захирлыг оролцуулан, захиргааны үүргийг гүйцэтгэдэг SFA-ийн ажилтнууд.
SFA-ээс зөвшөөрөгдсөн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)	SFA-ийн нэг эсвэл хэд хэдэн стандартын баталгаа болон баталгаажуулалтыг гүйцэтгэхээр SFA-ээс батламжилсан Тохирлын үнэлгээний байгууллага.
SFA Threads	“SFA Certified” ширхэгт/ширхэгтээр хийгдсэн бүтээгдэхүүний борлуулалт, боловсруулалт болон худалдан авалтыг мөшгөх онлайн дижитал хэрэгсэл болох SFA-ийн мөшгөлтийн платформын эзэмшлийн нэр.
Байх ёстой (на ⁴)	Аж ахуйн нэгжийн хангах ёстой шаардлагыг заана.
Салбар нэгж	Тодорхой газарзүйн байршилд SFA-ийн стандартын шаардлагад нийцэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг аливаа салбар нэгж. Газарзүйн хувьд ялгаатай эсвэл өөр өөр албан ёсны хаягтай байршлыг тусдаа салбар нэгж гэж үзнэ. Туслан гүйцэтгэгчийг салбар нэгж гэж авч үзэхгүй. Тайлбар: Монголын хувьд салбар нэгж нь зөвхөн нэг өрх (нэг бүтэн гэр бүл), бүл (2-3 гэр бүл) эсвэл нийтийн бэлчээр, усны эх үүсвэр, хашаа хороогоо хуваалцдаг хөрш (өөр хоорондоо ойрхон амьдардаг бүлэг гэр бүлүүд, Монгол хэлээр “айл саахалт” буюу хөрш айл). Жишээлбэл, малчны өрхийг салбар нэгж гэж үзнэ.
Ээрэх	Ширхэгтийг массаас сунгаж татан, хооронд нь эрчилж нэгтгэн тасралтгүй утас эсвэл ээрмэл утас болгох үйл явц.
СТСХ (Стандартын тогтолцоог сайжруулах хороо)	SFA-ийн стандартын боловсруулалт, засвар, удирдамж болон баталгааны шаардлагын чанар, бүрэн бүтэн байдлыг хянаж ажиллах SFA-ийн гишүүд, хэрэгжүүлэгч түншүүд болон бусад сонирхогч оролцогч талуудаас уригдан бүрдсэн бүлэг.

	https://sustainablefibre.org/wp-content/uploads/2024/11/SFA_SSIC_TermsOfReference_v2.0.pdf
Оролцогч талууд	SFA-ийн схемийн шийдвэр эсвэл үйл ажиллагааг сонирхогч эсвэл түүний нөлөөнд өртөж болох хувь хүмүүс эсвэл бүлэг.
Стандарт	Хамгийн тохиромжтой чанар эсвэл хүрэх түвшинг зөвлөлдөн тодорхойлсон, нийтлэгээр давтан ашиглах зорилгоор эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичиг. Стандарт нь дүрэм, шаардлага эсвэл шинж чанарыг тодорхойлж болно. Стандарт нь техникийн нөхцөл, нэр томъёо, аргачлал, дүрэм, арга зүйн заавар, жагсаалт, жишиг үзүүлэлт болон зааварчилгаа гэх мэт хэлбэртэй байж болно. Жишээлбэл үйлдвэрлэлийн орчны хувьд стандарт нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц эсвэл үйлдвэрлэлийн аргад хэрэглэдэг нэр томъёо, зохистой дадлын дүрэм, жагсаалт, дээж авах ба шинжилгээний арга, сав баглаа боодол, тэмдэглэгээ, шошгололт зэрэг шаардлагыг онцлон авч үзэж болно. Стандартыг худалдааг хөнгөвчлөх (харилцан орлох чанар, саад тотгорыг багасгах, тогтворгүй байдлыг бууруулах замаар), чанар болон аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийг хамгаалах зорилгоор ашигладаг.
Стандартын дүйцэл	Тухайн авч үзэж буй схемд хамааралтай, хэрэглэж болохуйц, ижил төстэй нөхцөлд тогтвортой байдлын гүйцэтгэлийн ижил түвшинг хангах бусад стандартын хүрэлцээт байдал. SFA-ийн дүйцлийн бодлого: https://sustainablefibre.org/wp-content/uploads/2025/10/SFA_EquivalencePolicyProcedure_v1.0.pdf
Стандарт чийгийн хэмжээ	“Чийгшүүлсэн жин”-г тодорхойлоход материалын хуурай жин дээр нэмсэн харилцан зөвшөөрсөн чийгийн хэмжээ (“Баталгаажсан ширхэгтийн жин”-г үзнэ үү.).
Стандартын тогтолцоог эзэмшигч	Стандартын тогтолцоог хариуцдаг байгууллага. Стандартын тогтолцоог эзэмшигч нь стандартын тогтолцооны зорилго, хамрах хүрээг тодорхойлохын зэрэгцээ тухайн схем хэрхэн хэрэгжих дүрэм болон нийцлийг үнэлэх стандартыг тогтоодог.
Стандартын тогтолцоо/схем	Стандартыг тогтоох, чадавхийг бэхжүүлэх, баталгаа, мониторинг үнэлгээ зэрэг стандартыг хэрэгжүүлэхэд холбоотой үйл ажиллагааг хариуцдаг байгууллагуудын нэгдэл.
Зорилтын мэдэгдэл	Стандарт боловсруулах/дахин хянах SFA-ийн зорилгыг оролцогч талуудад мэдээлж, уг үйл явцад нээлттэй оролцохыг урьсан олон нийтийн товч мэдэгдэл.
Туслан гүйцэтгэгч	Байгууллагын зүгээс “SFA Certified” материалтай холбоотой үйлчилгээг (жишээлбэл, хадгалалт, боловсруулалт) гүйцэтгүүлэхээр гэрээлсэн хуулийн этгээд/хувь хүн. Туслан гүйцэтгэгч нь баталгаажсан материалыг биетээр эзэмших боловч хууль ёсны өмчлөгч биш бөгөөд материалыг худалдан авагч байгууллагаас хараат бүс байна.
Нийлүүлэлтийн сүлжээ	Түүхий эдээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх материал, бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний нийлүүлэлт болон худалдан авалтад оролцдог бизнесийн аж ахуйн нэгжийн дэс дараалал.

Цогц нийлүүлэлтийн сүлжээ	Нэг толгой компани эсвэл аж ахуйн нэгж нь бие даасан туслан гүйцэтгэгчийн оролцоогүйгээр түүхий эд үйлдвэрлэлээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүх үйл ажиллагааныхаа дараалсан үе шатанд хууль ёсны бүрэн өмчлөл болон шууд хяналтыг хэрэгжүүлдэг нийлүүлэлтийн сүлжээ. Жишээлбэл, тухайн брэнд нь түүхий эд үйлдвэрлэх, анхан шатны боловсруулалт хийх, үйлдвэрлэл явуулах болон бүтээгдэхүүнээ жижиглэн худалдаалах бүх үйл ажиллагааг өөрөө гүйцэтгэж болно.
Салангад нийлүүлэлтийн сүлжээ	Тухайн компани нь үйлдвэрлэлийн үйл явцын хэд хэдэн дараалсан үе шатыг эзэмшдэг, хяналт тавьдаг боловч үйл ажиллагааныхаа тодорхой үе шатыг хараат бүс гүйцэтгэгчээр эсвэл гуравдагч талын ханган нийлүүлэгч этгээдээр гүйцэтгүүлж болох нийлүүлэлтийн сүлжээ. SFA-ийн Хэмжээнд суурилсан хураамжийн удирдамж
Хэсэгчилсэн нийлүүлэлтийн сүлжээ	Хэсэгчилсэн нийлүүлэлтийн сүлжээ (ХНС)-нд хэд хэдэн оролцогч талуудыг оролцуулан нийлүүлэлтийн сүлжээний тодорхой үе шатыг зарим нь, үлдсэн үе шатыг бусад талууд нь хариуцан бүгд нэг зорилгын төлөө хамтран ажилладаг. Энэ нь нийлүүлэлтийн сүлжээг хязгаарлагдмал/сонгомол байдлаар нэгдмэл байлгана.
Босоо тогтолцоот нийлүүлэлтийн сүлжээ	Компани нь нийлүүлэлтийн сүлжээний ихэнх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг боловч боломжтой зарим хэсгийг гаднаас гүйцэтгүүлэх уян хатан байдлаа хадгална.
Нөхцөл, шаардлага	Стандартын талаарх үндсэн мэдээллийг агуулсан баримт бичиг. Үүнд дараах зүйл багтана: a) Стандарт эсвэл стандартын элементийн хэрэгцээ шаардлагын үндэслэл; b) Ижил төстэй материал эсвэл асуудлыг хамарсан одоо мөрдөж буй стандартууд; c) Санал болгож буй хамрах хүрээ; үүнд газар зүйн бүс багтана; d) Стандартын тодорхой зорилт; e) Стандарт эсвэл стандартын элементийг хэрэгжүүлэхэд учрах эрсдэлийн үнэлгээ, тэдгээрийг хэрхэн бууруулах арга зам: i. Стандартын зорилгод хүрэх боломжид сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсийн тодорхойлолт; ii. Хэрэгжилтийн явцад гарч болзошгүй хүсээгүй үр дүн; f) Эдгээр болзошгүй эрсдэлийг бууруулахад авч хэрэгжүүлэх боломжит залруулах арга хэмжээ; g) Нөлөөлөлд өртөх оролцогч талуудын жагсаалт; Стандартын агуулга эсвэл хэрэгжилттэй холбоотой гомдол гаргах, санал өгөх үйл явц.
Гуравдагч талын баталгаа (ISEAL)	Баталгаа гаргуулах зүйлийг нийлүүлж буй хувь хүн эсвэл байгууллага болон тухайн зүйлийг хэрэглэгч этгээдийн сонирхлоос хараат бүс хувь хүн эсвэл байгууллагаар баталгаа гаргуулах үйл ажиллагаа.
Өөрчлөлтийн онол	Урт хугацааны тодорхойлсон зорилго эсвэл үр нөлөөнд хүрэхэд шаардлагатай бүх үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлдог

	төлөвлөлт ба удирдлагын хэрэгсэл. Энэхүү хоорондоо уялдаатай багц бүрэлдэхүүн хэсгүүд нь гарц болон богино, дунд хугацааны хүлээгдэж буй үр дагавараас бүрдэх бөгөөд эдгээрийн биелэлтийг үзүүлэлтээр хэмжиж, ихэвчлэн өөрчлөлтийн үйл явцыг илэрхийлсэн шалтгаан үр дагаварын дараалал байдлаар хүлээгдэж буй үе шатууд болон хоорондын холбоо хамаарлыг зураглан харуулдаг. Мөн өөрчлөлтийн онол нь шалтгаан үр дагаварын дараалал дахь логик болон үе шатуудын цаад мөн чанарыг тодорхойлдог (ISEAL).
Аюул занал	Байгууллагыг зорилгодоо хүрэхэд саад болж болох аливаа тохиолдол, үйлдэл, болзошгүй үйлдэл эсвэл эс үйлдэхүй. Тодорхой нөхцөл байдал дахь аюул заналын тохиолдох магадлал болон цар хүрээг үнэлснээр эрсдэлийн ангиллыг тодорхойлдог.
Мөшгөлт	Ямар нэг зүйлийг үйл явцын туршид шилжин хөдөлж буйг мөрдөх боломж. Үйл явцын гинжин хэлхээний үе шат бүрийн талаарх мэдээллийн бүрэн байдал нь тухайн материалын гарал үүсэлтэй холбоотой мэдээллийг шалгаж нотлох боломж олгодог.
Худалдаа эрхлэгч	“SFA Certified” гэж мэдэгдэл гаргасан материалыг хууль ёсоор өмчилдөг боловч биетээр эзэмшдэггүй аж ахуйн нэгж.
Борлуулалтын гэрчилгээ (БГ) / баримт	Нэг байгууллагаас нөгөөд худалдаалж байгаа эсвэл тээвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь тодорхой стандарт (жишээлбэл, SFA-ийн мөшгөлтийн тогтолцооны стандарт)-д нийцэж байгааг нотлохын тулд батламжлагдсан тохирлын үнэлгээний байгууллагаас олгодог баримт бичиг бөгөөд үүнийг хүлээн авагч нь “баталгаажсан” бүтээгдэхүүн гэж үзэж болно.
Борлуулалтын бүртгэлийн баримт (ББ)	Худалдаж буй бүтээгдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон бүтээгдэхүүнийг худалдан авагч, худалдагч талуудын мэдээллийг агуулсан цахим бүртгэл. Худалдан авагч болон худалдагчийн аль аль нь бүртгэлийг хүчин төгөлдөр болохоос өмнө болон Гүйлгээний гэрчилгээг олгогдохоос өмнө бүртгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг зөвшөөрсөн байх ёстой.
Шилжилтийн огноо	Стандартын дагуу олгогдох бүх гэрчилгээ нь уг стандартын тухайн хувилбарын дагуу олгогдож эхлэх огноо.
Баталгаажаагүй	SFA-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаагүй үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн.
Хязгаарлагдмал оролцоотой талууд	Схемийн шийдвэр, өөрчлөлт, үйл ажиллагаанд хамрагдаагүй эсвэл хэсэгчлэн хамрагдсан, мэдээлэл авсан, тодорхой ойлголттой бөгөөд схемийн шийдвэр, үйл ажиллагааг сонирхогч эсвэл түүний нөлөөлөлд өртөх хувь хүн буюу бүлэг.
Нотолгоо	Бүтээгдэхүүн эсвэл үйл явцад тавих шаардлагыг бодитоор хангасан эсэхийг объектив нотолгоонд тулгуурлан шалгаж, батлах үйл явц. Энэ нь дарайх хэлбэрээр ашиглагдаж болно: a) өмнөх мэдээлэл, өгөгдөлд үндэслэн тухайн мэдэгдлийн үнэн зөвийг үнэлэхэд b) өмнө болсон үйл явдлын талаарх мэдээлэл эсвэл аль хэдийн бий болсон үр дүнгийн мэдээлэлд үндэслэн мэдэгдлийн үнэн бодит байдлыг тогтоох

Хэмжээнд суурилсан хураамж (ХСХ)	Нийлүүлэлтийн сүлжээнд зөвхөн нэг удаа ногдуулдаг бөгөөд эцсийн брэнд эсвэл ширхэгт боловсруулах үйлдвэрийн төлдөг төлбөр. SFA-ийн Хэмжээнд суурилсан хураамжийн удирдамж
Нэхэх	Хоёр тусдаа багц утас эсвэл ээрмэлийг тэгш өнцгөөр огтолцуулан холбож даавуу эсвэл бөс материал үүсгэдэг нэхмэл үйлдвэрлэлийн арга.
Мэдээлэгчийг хамгаалах бодлого	Зөрчил, хууль бус үйлдэл мэдээлэгчийг тухайн шүгэл үлээх үйлдэлтэй нь шууд холбоотой байж болох аливаа шийтгэл, хариу арга хэмжээ эсвэл бусад сөрөг үр дагавраас хэрхэн хамгаалахыг тодорхойлсон баримт бичиг.
Ажилд ашиглах амьтан	Түүхий эд үйлдвэрлэлийн тогтолцооны хүрээнд хамгаалах, тээвэр хийх зэрэг тодорхой ажил гүйцэтгэхэд ашигладаг мал, амьтан. Ажилд ашиглах амьтанд ихэвчлэн ширхэгт нийлүүлэх амьтан, адуу гэх мэт тээвэрт ашиглагддаг мал эсвэл хоточ нохой орно. Харин гэрийн тэжээвэр амьтан нь ажилд ашиглах амьтан биш учраас SFA-ийн хамрах хүрээнд багтахгүй. Тухайн түүхий эд үйлдвэрлэлийн тогтолцооноос хамаарч зарим амьтан ширхэгт/махны үйлдвэрлэл болон тээвэрлэлт зэрэг хос чиг үүргийг зэрэг гүйцэтгэдэг.